



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХҮЙН ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү дүрмийг Монгол улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо-шаардлага, ОУХБ-ын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 155 конвенцын 164 дүгээр зөвлөмжийг үндэслэн боловсруулсан болно.

Хоёр. Зорилго, цар хүрээ

- 2.1. Энэхүү дүрэм нь байгууллагын ажиллагчдын хөдөлмөрлөх явцад ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн техник, технологийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эрсдэлд суурилсан цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.
- 2.2. Байгууллага дээр хэрэгжүүлж буй ХАБЭА-н бодлого, стандарт, журам, дүрэм, заавар нь тухайн байгууллагын бүх ажилтанд хамаарна.
- 2.3. ХАБЭА-н үйл ажиллагаа нь ажил эрхлэлтийн салшгүй хэсэг байна.

Гурав. Удирдлага зохион байгуулалт

- 3.1 ХАБЭА-н дүрмийн хэрэгжилтийг компанийн гүйцэтгэх захирал, уурхайн дарга ХАБЭА-н мэргэжилтнүүд удирдлагаар хангаж, хяналт тавина.
- 3.2 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны удирдлага нь “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн бүтцийн дагуу шаталсан хэлбэртэй байна.
- 3.3 “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн албадын дарга, уурхайн дарга, орлогч, ерөнхий инженер, алба, хэлтэс, салбар нэгжийн дарга, мастер нь тухайн салбар нэгжийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажиллагааг бүрэн хариуцна.
- 3.4 “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах ослоос урьдчилан сэргэжлүүлэх зорилгоор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг байгуулсан байна. Зөвлөл нь хурлаараа баталсан журмын дагуу ажиллана.
- 3.5 ХАБЭА-г бодлого, хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний агуулгын хүрээнд “Төлөвлөлт-Хэрэгжүүлэлт-Хяналт шалгалт-Дүн шинжилгээ” гэсэн үе шатаар, тасралтгүй сайжруулах зарчмаар хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 3.5.1 Төлөвлөлт нь ХАБЭА-г хуулиар хүлээсэн үүргийг биелүүлэх, зорилго, асуудлаа тодорхойлох, төлөвлөгөө арга хэмжээ боловсруулах, тэдгээрийг биелүүлэх хугацаа, хариуцах эзнийг тогтоох үйл явц,
 - 3.5.2. Хэрэгжүүлэлт нь төлөвлөсөн ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явц,
 - 3.5.3. Хяналт шалгалт нь хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь ХАБЭА-н бодлого, хууль тогтоомж болон бусад шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт хийж тайлагнах үйл явц,
 - 3.5.4. Дүн шинжилгээ нь хяналт шалгалтын үр дүнд шинжилгээ хийж үр дүнг

сайжруулах санал боловсруулах үйл явц юм.

3.6 ХАБЭА-н үйл ажиллагааны төлөвлөлтийн бүрэлдэхүүн хэсэгт:

- 3.6.1 Аюулыг таньж илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, удирдах
- 3.6.2 ХАБЭА-н хууль тогтоомжийн болон бусад шаардлагууд
- 3.6.3 Эдгээрийн хэрэгжүүлэх зорилго, зорилтууд
- 3.6.4 Санхүүжилтийг тусгасан байна.

3.7 Аюулыг таньж илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, удирдах хэсэгт дараах асуудлууд багтана.

3.8 Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ - Ажил олгогч нь үнэлгээг НХХ-ийн сайдын баталсан "Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам"-ын дагуу мэргэжлийн байгууллагаар заавал хийлгэнэ.

3.9 Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл - зөвшөөрлийг хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйл бүхий үйл ажиллагаа эрхлэхэд "Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу холбогдох төрийн хяналтын байгууллагаас авсан байна.

3.10 Эрсдэлийн удирдлага-эрсдэлийн үнэлгээг ажлын байр болгонд ажилтан, мэргэжлийн байгууллага болон ХАБЭА-н ажилтнуудыг оролцуулан хийх ба үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан ажлын байранд эрсдэлийн үнэлгээг дахин шинээр хийж, үнэлгээний дагуу эрсдэлийг бууруулах арга хэмжээ авна.

3.11 Шинэ техник технологи нэвтрүүлсэн, тоног төхөөрөмж суурилуулсан болон ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийг өөрчилж шинэчилсэн тохиолдол бүрд тэдгээрийг ажиллуулахын өмнө гарч болзошгүй аюулыг танин илрүүлэх, эрсдэлд нь үнэлгээ хийх, ноцтой аюул, эрсдэлийг хянах, удирдах механизмыг боловсруулж шинжилгээ хийнэ.

3.12 Ажил эхлэхийн өмнө ажлын байрны аюул эрсдэлийг заавал хэлэлцэнэ. Ажилтан бүр үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад тулгарсан аюулыг илрүүлж, шууд удирдлагадаа /мастер, механик, ахлах ажилтан гэх мэт/ мэдээлэх үүрэгтэй.

3.13 Урамшуулал - "Эрдэнэс Алт Ресурс" ХХК-ийн үйл ажиллагааны хүрээнд үйлдвэрлэлийн осол, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлийг бууруулах болон ХАБЭА-н ажлын үр дүнг үнэлэх, урамшуулах ажлыг зохион байгуулна.

Дөрөв.Зорилго зорилтууд

4.1 ХАБЭА-н зорилго зорилтууд нь ажлын гүйцэтгэлийг үнэлэх бодлогын шинжтэй, хүлээсэн үүрэг амлалтуудыг бүрэн хангаж тасралтгүй ахисан байна.

4.2 ХАБЭА-н бодлогыг хэрэгжүүлэх зорилго зорилтыг жил бүр хэлэлцэж батлах /Ерөнхий захирал, уурхайн дарга, ерөнхий инженер гэх зэрэг байгууллагын бүтцээс хамаарч үйл ажиллагаа, төсөв санхүүгийн эрх мэдэл бүхий албан тушаалтан байна/

ХАБЭА-г сайжруулах иж бүрэн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулах /ХАБЭА -н хэлтэс, албадын дарга буюу хариуцсан ажилтан/

4.3 ХАБЭА-г сайжруулах талаар санал бэлтгэх /ХАБЭА-н хэлтэс, албадын дарга буюу хариуцсан ажилтан/

Тав.Санхүүжилт

5.1. ХАБЭА-г хангахад чиглэсэн шаардлагатай зардлыг Монгол улсын "Хөдөлмөрийн

аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 26.2 дугаар хэсэгт заасны дагуу компанийн

ХАБЭА-н зардлаас санхүүжүүлнэ. /ХАБЭА-н зардлын бүрдлийг эрх бүхий байгууллага салбарын хэмжээнд хэрхэн заасныг үндэслэн төлөвлөнө.

Зургаа.Хэрэгжүүлэлт

6.1 ХАБЭА-н удирдлага, үйл ажиллагааны хэрэгжүүлэлт нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

6.1.1 Эрх - Ажил хөдөлмөр эрхэлж байгаа ажилтан нь ХАБЭА-н шаардлага хангасан ажлын байранд ажиллах, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, эрүүл мэндэд учирч болох эрсдэл, үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн талаар бодит мэдээлэл авах, ажил үүргээ биелүүлэх явцад ХАБЭА-н журам, дүрэм зөрчигдсөн болон эрүүл мэнд, амь насанд нь сөрөг, аюултай нөхцөл бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, энэ талаар ажил олгогчид мэдэгдэх эрхтэй.

6.1.2 Үүрэг - Ажил олгогч нь захиргааны хяналтыг өндөржүүлэх, аливаа ажиллагааг гүйцэтгэх ажлын дадлага туршлагатай болгох, ажилтны хамгаалах хэрэгслийн зөв хэрэглээг хангах, аюулгүй ажиллагааг хангах, эрсдэлийг бууруулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй. Ажилтан нь ХАБЭА-н талаар тулгарсан хүндрэл, үүссэн үл нийцлийг ажил олгогчид мэдээлэх, ажил олгогч ажилтны мэдээллийг хүлээн авч зохих арга хэмжээг цаг тухайд нь авах үүрэгтэй бөгөөд ул буруутгах зарчим баримтална. ХАБЭА-н шаардлагыг “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн гэрээт, туслан гүйцэтгэгч байгууллагуудын ажилтнууд дагаж мөрдөх үүрэгтэй.

6.1.3 Хариуцлага - Ажил олгогч нь ажилтнуудын аюулгүй байдлыг хангах хариуцлагыг хүлээнэ. Ажилтан ХАБЭА-н журам, дүрэм, заавар, тэмдэг тэмдэглэгээг санаатайгаар зөрчих, осол аваар гаргасан тохиолдолд ажил олгогч нь зохих арга хэмжээ авна. ХАБЭА-н зөвлөл нь тохиолдол бүрийг хэлэлцэн Монгол улсын “Хөдөлмөрийн тухай” хуулийн дагуу сахилгын шийтгэл оногдуулах саналыг ажил олгогчид уламжилна. Ажил олгогч нь ажилтны ХАБЭА-н талаар эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг Хөдөлмөрийн гэрээ, Ажлын байрны тодорхойлолтод тусгана.

Долоо.Сургалт

7.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт нь гадаад ба дотоод сургалт явуулах, зааварчилга өгөх хэлбэрээр явагдах ба сургалт нь тасралтгүй сургах зарчим дээр үндэслэгдэн дараах төрлүүдээр явагдана. Үүнд:

7.1.1. Нийт ажилтны сургалт

7.1.2. Аж ахуйн нэгж байгууллагын ажил олгогчийн сургалт,

7.1.3. Хөдөлмөрийн аюулгүй - байдал, эрүүл ахуйн хариуцсан ажилтны сургалт

7.1.4. Шинээр ажилд орж байгаа ажилтны сургалт

7.1.5. Өөр ажлын байранд шилжсэн ажилтны сургалт

7.1.6. Үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл, тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтны сургалт

7.2 “Эрдэнэс Алт Ресурс” ХХК нь аюулгүй ажиллагааны сургалтыг тусгайлсан хөтөлбөртэйгөөр жилд 26-аас доошгүй цагийн сургалтыг 11 сарын 1-ний өдрөөс 4 сарын 1 хүртэл хугацаанд явуулж, мэдлэгийн шалгалтыг авч тэнцсэн ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлнэ.

7.3 Уурхайн хэмжээнд удирдах албан тушаалтан, инженер техникийн ажилтны

мэдлэгийн шалгалтыг 2 жилд нэг удаа ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан авна.

7.4 Сургалт зааварчилгааны хөтөлбөр, хичээлийн сэдвийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан боловсруулж, "Эрдэнэс Алт Ресурс" ХХК-ийн ХАБЭА-н зөвлөл, гүйцэтгэх захирал батална.

7.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, зааварчилгааг "ХАБЭА-н сургалт, зааварчилгаа явуулах, шалгалт авах тухай журам" -ийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын сайдын баталсан тушаалыг үндэслэн баталж мөрдөнө.

7.6 "Эрдэнэс Алт Ресурс" ХХК-ийн ХАБЭА-н үйл ажиллагаанд удирдах ажилтнуудыг мэргэшүүлэх бодлого боловсруулж мөрдөх ба ХАБЭА-н ажилтан, инженер техникийн ажилтнуудын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх сургалтыг жилд 2-оос дээш удаа зохион байгуулна.

7.7 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мэдээлэл, сургалтыг мэдлэг сорих тэмцээн, ослын сэрэмжлүүлэг, видео болон радио хурал, видео зайн сургалт, хэвлэл мэдээлэл, сурталчилгаа гэсэн хэлбэрүүдээр зохион байгуулна.

7.8 Удирдах ажилтныг мэргэшүүлэх сургалтыг ХАБЭА-н сургалт явуулах тусгай зөвшөөрөл бүхий байгууллага болон мэргэжлийн холбооны сургалтын төвийн тусгайлсан хөтөлбөрийн дагуу сургана.

7.9 . ХАБЭА-н зааварчилгааг дараах гурван хэлбэрээр өгнө. Үүнд:

7.9.1. Урьдчилсан зааварчилгаа (шинээр ажилд орж байгаа ажилтны сургалт)

7.9.2. Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа

7.9.3. Давтан зааварчилга (ээлжит, ээлжит бус, ажлын байран дахь өдөр тутмын)

7.10 Урьдчилсан зааварчилгааг шинээр ажилд орсон ажилтан, үйлдвэрлэлийн дадлага хийхээр ирсэн оюутан, суралцагчдад тэдний ажилласан жил, боловсролын түвшнийг харгалзахгүйгээр, хөдөлмөрийн тухай хууль тогтоомж, ХАБЭА-н стандарт, дүрэм, журам, заавар, галын аюулгүй байдал, хувийн хамгаалах хэрэгсэл, YOXX, МШӨ үүсэх шалтгаан, осолдогчдод үзүүлэх анхны тусlamж гэсэн агуулгаар 2-оос доошгүй цагаар өгч, урьдчилсан зааварчилгааны дэвтэрт хүний нөөцийн ажилтан хяналтын хуудасны дагуу бүртгэнэ.

7.11 Анхан шатны зааварчилгааг ажлын байр өөрчлөгдсөн болон урьдчилсан зааварчилгааг авч ажилд шинээр орж буй ажилтан, үйлдвэрлэлийн дадлага хийх гэж буй оюутан, суралцагч наарт тухайн ажилтны ажлын байрны үйлдвэрлэлийн ажиллагаа, гүйцэтгэх ажлын онцлог, машин техник, багаж, хэрэгсэл ашиглах болон ажлын явцад үүсэж болох сөрөг хүчин зүйл түүнээс хамгаалах хэрэгсэл , тэдгээрийг ашиглах заавар, аюулгүй ажиллагааны арга барил, үйлдвэрлэлийн өргөх, тээвэрлэх машин механизм, даралтат сав, шугам хоолой, цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт , аюулгүй ажиллагааны шаардлага, галын аюулгүй байдлыг хангах журам, гал түймэр гарсан үед авах арга хэмжээ, гал унтраах хэрэгсэл, тэдгээрийг ашиглах, хадгалах, осолдогчдод үзүүлэх анхны тусlamж гэсэн агуулгаар тухайн ажлын байрыг хариуцсан цех, тасаг, хэсгийн дарга, мастер биечлэн өгч, ажилтнаас шалгалт аван хангалттай гэж үзвэл уг ажилтанд бие даан ажиллах зөвшөөрөл олгоно.

7.12 Давтан зааварчилгааг ажилтанд өмнө олгосон мэдлэгийг бататгах, баяжуулах зорилгоор анхан шатны зааварчилгааны агуулгаар улиралд нэгээс доошгүй удаа өгнө.

7.13 ХАБЭА-н дүрэм, зааврыг ноцтой зөрчсөн, YOXX, МШӨ гарсан хэсэг, цех, тасгийн ажилтанд, мөн нэг сараас илүү хугацаагаар ажлаасаа хөндийрч, ажилдаа эргэн орсон

ажилтанд ээлжит бус давтан зааварчилгааг өгнө.

7.14 Өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажилтны хийж гүйцэтгэх уйл ажиллагаанд тохирсон, осолгүй ажиллахад чиглэгдсэн, болзошгүй ослоос сэрэмжлүүлж, салбар нэгжийн даргын томилсон тухайн цех, хэсгийн дарга, мастер инженер ажил эхлэхийн өмнө, 15 минутаас багагүй хугацаанд тухай бүрд бичгээр, аргачилсан байдлаар өгнө. Түүний эзгүйд албан ёсоор томилогдсон албан тушаалтан өгч болно.

7.15 Аюултай ажил гүйцэтгэдэг ажилтанд ажил эхлэхийн өмнө товч тодорхой бичгээр өгнө.

7.16 Урьдчилсан, ажлын байрны анхан шатны, давтан болон ажлын байрны өдөр тутмын зааварчилга өгсөн тухай тусгай журналд зааварчилга өгсөн огноо, зааварчилгааны утга, сэдэв зааварчилга өгсөн ба авсан ажилтан, албан тушаалын овог, нэрийг бичиж гарын үсэг зуруулж баталгаажуулсан байна.

7.17 Ээлжит давтан зааварчилгааг дараах зарчмаар өгнө. Үүнд :

7.17.1. “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн удирдлага (Гүйцэтгэх захирал, уурхайн дарга, орлогч), мастер, инженер ХАБЭА-н асуудал хариуцсан хэлтэс, зөвлөлөөс хамтарч ээлжит ба ээлжит бус давтан зааварчилгааг өгч, бүртгэн, баталгаажуулна.

7.17.2.Хэлтэс, албаны дарга нар ээлжит давтан зааварчилгааг харьяа салбар нэгжийн дарга, удирдлагын бүх ажилтанд улирал бүр өгөх ба ХАБЭА хариуцсан ажилтан өгч болно.

7.17.3.Салбар, нэгжийн дарга нар бүх удирдах албан тушаалтнуудад ээлжит давтан зааварчилгааг улиралд нэг удаа өгөх ба даргын шийдвэрээр ХАБЭА хариуцсан инженер өгч болно.

7.17.4.Хэсгийн мастер, шаардлагатай тохиолдолд ахлах мастер, инженерүүд нь бригадын дарга, ажилтанд ээлжит давтан зааварчилгааг улиралд нэг удаа давтан сургалтын хэлбэрээр өгнө.

7.18 Ээлжит бус давтан зааварчилгааг хөдөлмөрийн нөхцөл өөрчлөгдөх, ХАБЭА-н дүрэм, журам, заавар шинэчлэгдэх, байгалийн гамшиг, цаг агаарын тааламжгүй нөхцөл үүсэх, шинэ технологи, машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглалтад оруулах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан, албан томилолтоор 1 сараас дээш хугацаагаар өөр ажил үүрэг гүйцэтгэсэн, жирэмсэн болон хүүхэд асрах чөлөө авсан, ээлжийн амралт эдлээд эргэж ирсэн тохиолдлуудад ээлжит хугацаанаас өмнө өгнө.

Найм. Мэдээлэл

8.1 ХАБЭА-н мэдээ, мэдээллийг хүлээн авах, түгээх, баримтжуулах, хариу өгөх үйл ажиллагааг ХАБЭА-н зөвлөлийн баталсан тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хийнэ.

Ес. Эрүүл мэндийг хамгаалах

9.1 Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, мэргэжлээс шалтгаалах өвчинөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл ажиллах, амьдрах ухаанд сургах, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг сургалтын хэлбэрээр хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хийнэ.

Арав. Баримтжуулалт

10.1 “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн ХАБЭА-н үйл ажиллагаанд дараах баримт бичгүүд байна. Үүнд:

- 10.1.1. Анхан шатны баримт бичгүүд
- 10.1.2. Ажлын байрны тодорхойлол
- 10.1.3. Заавар
- 10.1.4. Дотоод дүрэм, журам
- 10.1.5. Хөтөлбөр, төлөвлөгөө
- 10.1.6. Дотоод стандартууд байна.

10.2 ХАБЭА-н баримт бичиг нь ХАБЭА-н тухай хууль, стандарт болон бусад шаардлагад нийцсэн баримт бичиг боловсруулах шаардлагыг хангасан, оновчтой, товч, тодорхой байна.

10.3 ХАБЭА-н журам, дүрэм, заавар, технологийн картыг 5 жил тутамд хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчилж, үйлчлэх хугацааг сунгаж байна.

10.4 ХАБЭА-н баримт бичгийн бүртгэлийг тухайн нэгж, хэлтэс, албад хийж хяналт тавина.

10.5 ХАБЭА-н талаар хөтлөгдөх баримт бичгийн нэгдсэн жагсаалтыг ХАБЭА-н ажилтан гаргаж байгууллагын удирдлагаар батлуулсан байна. Үүнд:

- 10.5.1. Амьсгал дахь спиртийн агууламж шалгах хуудас
- 10.5.2. Шөнийн болон ажлын бус цагаар уурхайгаас гарах зөвшөөрөл
- 10.5.3. Аюулыг мэдээлэх хуудас
- 10.5.4. Ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийн эдэлгээний хугацаа
- 10.5.5. ХАБЭА-н урамшуулал олгох журам
- 10.5.6. Ослын мэдүүлэг
- 10.5.7. Ачаа өргөхийн ёмнөх шалгах хуудас
- 10.5.8. Ажилчид болон тээврийн хэрэгсэл төслийн талбай руу явахад дагаж мөрдөх журам

- 10.5.9. Төслийн талбайгаас ажилчид тээврийн хэрэгсэл гаргах журам
- 10.5.10. Осол гарах үед авах арга хэмжээ
- 10.5.11. Ахлах ажилтны АА хүлээх үүрэг
- 10.5.12. Уурхайн доторх замын тэмдэг тэмдэглэгээ, урсгал тусгаарлах зурvas
- 10.5.13. Ажилтны хүлээх үүрэг
- 10.5.14. Амралт болон ажлаас буухдаа хийх зайлшгүй зүйлүүд

10.6 ХАБЭА-н тусгайлсан дүрэм зааврыг ХАБЭА-н дүрэм заавар боловсруулах тухай журмын дагуу боловсруулсан байна.

10.7 Зохицуулалт - Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь дараах асуудлуудыг багтаана. Үүнд:

- 10.7.1. Техникийн зураг төсөл боловсруулах
- 10.7.2. Машин механизм, тоног төхөөрөмж, инженерийн байгууламжийг ашиглах
- 10.7.3. Тоног төхөөрөмж, материал нийлүүлэх
- 10.7.4. Ажилтныг шинээр ажилд авах
- 10.7.5. Ажилтныг хамгаалах хэрэгслээр хангах
- 10.7.6. Ажил гүйцэтгэх үед аюулгүй байдлыг хангах
- 10.7.7. Аюултай ачааг тээвэрлэх

10.8 Техникийн зураг төсөл боловсруулах-Техникийн зураг төсөл боловсруулахад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, техникийн шаардлагыг хангаж, холбогдох

төрийн хяналтын байгууллагатай зөвшилцсөн байна.

10.9 Машин механизм, тоног төхөөрөмж, инженерийн байгууламжийг ашиглах - Машин механизм, тоног төхөөрөмж, инженерийн байгууламж нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх ба шаардлагатай тохиолдолд технологийн карт боловсруулна. Цахилгаан хөдөлгүүртэй тоног төхөөрөмж дээр ажиллах үед пайзлах-циожлох журмыг мөрдөнө.

10.10 Барилга байгууламжийг аюулгүй ашиглах - Барилга байгууламжийн аюулгүй ашиглалтыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа барилгын норм, дүрмээр зохицуулна.

10.11 Тоног төхөөрөмж, материал нийлүүлэх - "Эрдэнэс Алт Ресурс" ХХК-д нийлүүлэгдэж буй тоног төхөөрөмж, материал нь аюулгүйн ажиллагааны шаардлагыг хангасан, ашиглалтын паспорт, гэрчилгээтэй байх ба тэдгээрийг ханган нийлүүлэхэд техникийн нөхцөл, зохих зөвшөөрлийг үндэс болгоно.

10.12 Ажилтныг шинээр ажилд авах - Шинээр ажилд орж байгаа иргэн нь мэргэжлийн дагуу эрх бүхий сургалтын байгууллагад суралцаж төгссөн үнэмлэх, диплом, гэрчилгээтэй, эмнэлгийн үзлэгээр орж тухайн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд ажиллаж болох тухай эмч нарын дүгнэлт гаргуулсан, ХАБЭА-н сургалтад хамрагдаж шалгалт өгсөн байна.

10.13 Ажиллагсдыг хамгаалах хэрэгслээр хангах - "Эрдэнэс Алт Ресурс" ХХК-ийн ажилтнуудыг "Ажилтныг хамгаалах хэрэгслээр хангах" журмын дагуу хамгаалах хэрэгслээр хангана.

10.14 Ажил гүйцэтгэх үед аюулгүй байдлыг хангах асуудлыг "Ажил гүйцэтгэх үед ХАБЫГ хангах тухай журам"-аар зохицуулна. Энэхүү журам нь ажил гүйцэтгэх үед наряд-даалгавар, онц аюултай нөхцөлд ажил гүйцэтгэх үед наряд-зөвшөөрөл, гаднын байгууллага, хувь хүнээр ажил гүйцэтгүүлэх үед зөвшөөрөл олгох асуудлыг зохицуулна.

10.15 Аюултай ачааг тээвэрлэх - Аюултай ачааг тээврийн хэрэгслээр тээвэрлэхэд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох журам, дүрмийг мөрдлөг болгоно.

Арван нэг. Гамшгаас хамгаалах бэлэн байдал

11.1 "Гамшиг" гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

11.2 "Гамшгаас хамгаалах" гэж гамшгийн аюулаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, эдгээр үйл ажиллагаанд хүн амьтгүй сургаж бэлтгэх цогцолбор арга хэмжээг хэлнэ.

11.3 Галын аюулгүй байдлыг хангах - Галын аюулгүй байдлыг хангах асуудлыг "Галын аюулгүй байдлын журам"-аар зохицуулна.

11.4 Цацрагийн аюулгүй байдлыг хангах - Цацрагийн аюулгүй байдлыг хангах асуудлыг "Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын журам"-аар зохицуулна.

11.5 Химийн аюулгүй байдлыг хангах - Химийн аюулгүй байдлыг хангах асуудлыг "Химийн аюулгүй байдлын дүрэм"-ээр зохицуулна.

11.6 ХАБЭА-Н онцгой горим тогтоох - ХАБЭА-ны хууль тогтоомж, журам, дүрэм, заавруудын шаардлагуудыг олон дахин ноцтой зөрчсөн, осол аваарын түвшин эрс

нэмэгдсэн цех, хэсгүүдэд осол аваарын түвшин эрс нэмэгдсэн цех, хэсгүүдэд ХАБЭА-н шаардлагыг хангах, ажилтнуудын ХАБЭА-н талаар хүлээх хариуцлагыг дээшлүүлэх, ХАБЭА-н ажлыг сайжруулах талаар шуурхай арга хэмжээ авах зорилгоор “ХАБЭА-н онцгой байдлын журам”-ын дагуу тогтооно.

Арван хоёр.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт, шалгалт

12.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын системийн хяналт, шалгалт нь дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.Үүнд:

12.1.1 Хэмжилт - Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн серөг хүчин зүйлийн хэмжилт, шинжилгээг ХАБЭА-н “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн серөг хүчин зүйлд хэмжилт, шинжилгээ хийх тухай журам”-ын дагуу гүйцэтгэнэ.

12.1.2 Хяналт аудит - Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь дараах асуудлуудыг багтаана. Үүнд:

12.1.2.1 Хяналт

12.1.2.2 ХАБЭА-н зөвлөл

12.1.2.3 Дотоод, гадаад аудит

12.1.3. Үйлдвэрлэлийн осолд дөхсөн тохиолдол, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, ослыг судлан бүртгэх - Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь дараах асуудлуудыг багтаана. Үүнд:

12.1.3.1. Үйлдвэрлэлийн осолд дөхсөн тохиолдлыг судлах - Үйлдвэрлэлийн осолд дөхсөн тохиолдол бүрийг үйлдвэрлэлийн осол, хурц хордлоготой нэгэн адил судална. Судалгааны үр дүнг “дотоод мэдээллийн сан”-д оруулж ажилтнуудад танилцуулна.

12.1.3.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх - Үйлдвэрлэлийн осол,хурц хордлогыг Монгол Улсын Засгийн газраас баталсан үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу судалж бүртгэнэ.

12.2 Хяналт: ХАБЭАУС-ийн хяналт нь дараах төрлүүдээс бүрдэх ба “ХАБЭА-н хяналтын системийн журам”-ын дагуу гүйцэтгэнэ.

12.2.1.1. Дөрвөн шатны хяналт

12.2.1.2. Зорилтот хяналт

12.2.1.3. Шуурхай мониторинг

12.3 ХАБЭА-н зөвлөл:

12.3.1 “Эрдэнэс Алт Ресурс” ХХК ХАБЭА-н зөвлөлийг Гүйцэтгэх захирлын тушаалаар ажилтны төлөөллийн бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллана.

12.3.2 ХАБЭА-н зөвлөл нь үйл ажиллагаагаа “ХАБЭА-н зөвлөлийн ажиллах журам”-ийн дагуу явуулж үйл ажиллагааны талаар компанийн захиргаа, хамт олны өмнө жил бүр тайлагнана.

12.4 Дотоод, гадаад аудит:

12.4.1 ХАБЭАУС-ийн дөрвөн шатны хяналтын дөрөв дэх шатны буюу иж бүрэн хяналтыг компанийн холбогдох хэлтэс, албадын оролцоотойгоор дотоод аудитын хэлбэрээр явуулна.

12.4.2 Гадаад аудит: ХАБЭА-н үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус ба олон улсын байгууллагаар гадаад аудитыг гэрээ, хэлэлцээрийн дагуу хийж болно.

12.4.3 Дотоод аудит : Ажил олгогч нь үйлдвэрлэлийн цех, тасаг, хэсэг, ажлын байр бүрд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, нийтлэг шаардлага, стандартын хэрэгжилт, ажлын байран дахь эрсдэлийн үнэлгээний дагуу

авагдсан арга хэмжээний биелэлтэд аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын хяналт тавина.

12.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтыг З үе шаттай зохион байгуулна.

12.5.1 1-р шатанд: Ил уурхай, баяжуулах үйлдвэрийн мастерууд ээлж, бригадын ахлахууд

12.5.2 2-р шатанд: Хүдрийн ил уурхай болон баяжуулах үйлдвэр, байгууллагын доторх нэгж хэсэгт

12.5.3. 3-р шатанд: Уурхайг бүхэлд нь хамарч явуулна.

12.5.4. 4-р шатанд: ХАБЭА-н зөвлөл байгууллагыг бүхэлд нь хамарч явуулна.

12.6 Анхан шатны хяналтыг тухайн хэсгийн ахлагч, мастер, ээлжийн дарга нар өдөр бүр ажил эхлэхийн өмнө, шаардлагатай үед / онцгой, аюултай ажил гүйцэтгэх гэх мэт/ ажлын өдрийн дундуур хийнэ. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг анхан шатны хяналтын дэвтэрт тэмдэглэж, тэдгээрийг арилгах арга хэмжээг төлөвлөж, хариуцах, гүйцэтгэх ажилтан, хугацааг тодорхойлно. Гүйцэтгэлийг уурхайн дарга, ерөнхий инженерт илтгэж байна.

12.7 “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн гүйцэтгэх захирал, уурхайн дарга, ерөнхий инженер, ХАБЭА-н ажилтан нар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд тавих хяналтыг 3-р шатны болон 2-р шатны үзлэгээр хийж, биелэлтийг үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ.

12.8 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнууд болон алба хэсгүүд нь харьяа салбар нэгжүүдийн хөдөлмөрийн аюулгүй байдалд улиралд 2-с доoshgүй удаа үзлэг, шалгалт хийж үр дүнг хэлэлцэж байна.

12.9 ХАБЭА-ны ажилтан нь бүх алба хэлтэс, салбар нэгжүүдэд улиралд 1-с доoshgүй удаа хяналт шалгалт хийнэ.

12.10 Хөдөлмөрийн аюулгүй байдал.эрүүл ахуйн зөвлөл болон алба хэлтсүүд нь харьяа салбар нэгжүүдийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажлыг эрсдэлийн хяналтын системийн шалгуур үзүүлэлтүүдээр дүгнэж үнэлгээ өгч ажиллана.

12.11 Алба, хэлтэс салбар нэгжийн дарга нар салбар нэгжийнхээ хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлыг шууд хариуцна.

12.12 Хоёр болон гуравдугаар шатны үзлэг шалгалт, мөн эрх бүхий байгууллагуудаас хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд явуулсан үзлэг шалгалтын мөрөөр өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлэх үүрэгтэй.

12.13 Хүдрийн ил уурхай, баяжуулах үйлдвэрийн хэсгийн дарга, ахлах мастер, инженерүүд харьяа ажлын байруудад 14 хоногт 1 удаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны эрсдэлийн хяналтын системээр хяналт тавьж 3 шатны хяналтын 2 дугаар шатанд бичлэг хийж, биелэлтийг хангуулна.Хяналт хамтарсан байж болно.

12.14 Ажилтан ажил эхлэхийн өмнө 15 минутаас багагүй хугацаагаар ажлын байрандаа эрсдэлийн хяналтын системийн дагуу хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилга арга хэмжээ авсны дараа ажил эхлэх буюу удирдах албан тушаалтанд мэдэгдэж 3 шатны хяналтын системийн дагуу хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авсны дараа ажил эхлэх буюу удирдах албан тушаалтанд мэдэгдэж 3 шатны хяналтын 1 дугаар шатанд бичлэг хийнэ.

12.15 Ослыг судлан бүртгэх - Ослыг “Ослыг судлан бүртгэх журам”-ын дагуу судалж

бүртгэнэ.

12.16 Төрийн хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах - Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, зам тээврийн ослын шалтгаан, нөхцөл байдлыг судлан бүртгэж, ХАБЭА- н урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж төлөвлөхөд холбогдох төрийн хяналтын байгууллагуудын шаардлага, зөвлөмжийг удирдлага болгон, тус байгууллагуудтай нээлттэй ажиллах зарчмыг баримтална.

Арван гурав.Дүн шинжилгээ

13.1 ХАБЭА-н бодлого, ХАБЭАУС-ийн хэрэгжилтэд компанийн удирдлага дүн шинжилгээ хийж, жил бүрийн бизнес төлөвлөгөөнд аюул, эрсдэлийг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээг тусгаж ажиллана.

—оOо—